



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд “Тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх” аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 06 сарын 27 өдрийн
144 дугаар тушаалын хавсралт



д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Регистрийн дугаар
1	"Мега пресс" ХХК	Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх	6266495
2	"Төгрөг дугаар" ХХК		5838657
3	"Номгон авто" ХХК		6251722
4	"Монголиа леадинг констракшн" ХХК		5540917
5	"Ундрам авто" ХХК		5916682
6	"Шанд жолоо" ХХК		3313832

-----oOo-----